



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/126

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 04 дүгээр өргөтгөсөн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд нарийн өвс, ногоон тэжээлийг дахин бүрдүүлэхэд шаардагдах 84,092,000 (наян дөрвөн сая ерэн хоёр мянга) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 84,092,000 (наян дөрвөн сая ерэн хоёр мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/31 дүгээр захирамжаар сумдад хямдралтай үнээр олгосон өвс, ногоон тэжээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй

3. Дээрх ажлыг зохион байгуулж, өвс, ногоон тэжээл нийлүүлсэн иргэн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, татан авах ажлыг шуурхай явуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Сумъяасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

0224 11 0304

Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 126 дугаар захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ХУУВАРЬ

Д/д	Нарийн өвс нийлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ (сая төгрөг)
1	Тод хүлэг ХХК	4081	9,000	36,729,000
2	Ц.Батжаргал	1105	17,000	18,785,000
3	ӨСӨХ ОКТО ХХК	921	18,000	16,578,000
4	О.Лхагва-Очир	600	20,000	12,000,000
	Нийт	6707		84,092,000

-оОо-